



**ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



**ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ**

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



**ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ**  
**2.8 ТЭРБУМ ДОЛЛАР**



**ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ**  
**9.1%**



**НИЙТ ХАДГАЛАМЖ**  
**11 ИХ НАЯД ТӨГ**



**ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС**  
**1.015 НЭГЖ**



**ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ**  
**805 ТЭРБУМ ТӨГ**



**МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ**  
**10%**

**ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)**

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +4.0%, 2018 онд: +3.0%

Инфляци: 2017 онд: +3.0%, 2018 онд: +3.4%

Урсгал тэнцэл: 2017 онд ДНБ-ий -6.4%, 2018 онд: -8.5%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zwQ36D>

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +2%, 2018 онд: +2.5%

Инфляци: 2017 онд: +4.4%, 2018 онд: +6%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2017 онд: -4.9%, 2018 онд: -8.7%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА**

**Төсвийн тэнцэл 2-р сарын байдлаар 73.1 тэрбумын ашигтай гарав.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 15.1 хувиар өсч, зарлага 4.9 хувиар буурч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 73.1 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 65.5 хувиар буурсан байна.



**Ам.долларын ханш өмнөх сараас 22 төгрөгөөр буурав.**

Хоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 75 төгрөг буюу 3 хувиар, өмнөх сартай харьцуулахад 22 төгрөг буюу 0.9 хувиар буурч 2402.90 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 2.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 151% нэмэгдсэн байна.




**Инфляцийн түвшин 6.9%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 2-р сард өмнөх сараас 0.8 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, эм эмнэлэгийн барааны үнэ хамгийн их өсөхөд нөлөөлсөн байна.




**Гадаад худалдааны тэнцэл 112.3 сая.ам доллар болов.**

2018 оны хоёрдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 1564 тэрбум төгрөг буюу 18 хувиар өсөв. Экспорт өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 47 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 112.3 сая ам.долларын ашигтай гарлаа.



## 2-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 2-р сард өмнөх сараас 1.2%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 9.8%-иар нэмэгдэж 13.8 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1266 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.2%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 18.3 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.1% байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 2 дугаар сарын эцэст 993 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 56 (6.%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 57.4 (5.5%) тэрбум төгрөгөөр буурлаа. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны 2 дугаар сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 72.5 (6.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 196 (18.3%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.2 хувийг эзэлж байна.

Харин үнэт цаасны арилжаагаар 2018 оны 2 дугаар сарын эцэст 3.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 3.2 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 231.3 (98.5%) тэрбум төгрөгөөр буурчээ. Арилжсан үнэт цаас өмнөх оны мөн үеэс 1.6 (34.0%) сая ширхгээр буурчээ.

## САРЫН ОНЦЛОХ: АЛТНЫ ХЭМЖЭЭ ӨСӨВ, НҮҮРСНИЙ ЭКСПОРТ БУУРАВ

- Монголбанк өнгөрсөн сард 1128 кг алт худалдан авав. Энэ нь өмнөх оны мөн үед 770 кг алт авч байснаас 358 кг-аар илүү буюу 46.5 хувиар өссөн үзүүлэлт гарчээ. Өнгөрсөн нэгдүгээр сарын байдлаар Лондонгийн үнэт металлын захын алтны ханш өндөр байгаагаас шалтгаалан 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 103 531.75 төгрөг болов. Төвбанкны алт худалдан авах үнэ өндөр байгаагаас шалтгаалан Монголбанкинд тушааж буй алтны хэмжээ өсөх хандлагатай байна.
- Монгол Улс өнгөрөгч нэгдүгээр сард дэлхийн 98 улстай худалдаа хийснээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 785 ам.долларт хүрчээ. Экспорт нэгдүгээр сард өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгдсэн хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 23.7 сая ам.доллар, буюу нүүрсний экспорт 31.2 сая ам.доллар буурсан үзүүлэлттэй байна. 2017 онд гадаад худалдааны тэнцэл 151.4 сая ам.долларын ашигтай гарч байсан бол өнгөрсөн нэгдүгээр сард өмнөх оны мөн үеэс 88.6 сая ам.доллороор буюу 58.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 2-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 2-р сар 2018 он, Монголбанк
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)